

Энэхүү ТМТ-ийн орчуулгыг 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн Англи хэл дээрх хувилбарт үндэслэн хийв.



## Төслийн Мэдээллийн Тайлан

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ) – д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг. ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай илтгэдэг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба нэмэлт мэдээллийг бэлэн болсон нь нэмж оруулдаг. Хэрэгжихээр төлөвлөгдсөн төслийн талаарх мэдээлэл урьдчилсан байдлаар байгаа бөгөөд илтгэх шинж чанартай.

ТМТ-г үүсгэсэн огноо	–
ТМТ-г шинэчилсэн	2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Төслийн нэр	Эрчим хүчний үр ашиг болон хотын хүрээлэн буй орчинг сайжруулах
Улс	Монгол Улс
Төсөл/Хөтөлбөрийн дугаар	46343-001
Статус	Санал болгосон
Газар зүйн байршил	–

Аливаа орны хөтөлбөр, түншлэлийн стратеги боловсруулах, аливаа төслийг санхүүжүүлэх болон энэхүү баримт бичигт тодорхой газар нутаг, газар зүйн нутаг дэвсгэрийг нэрлэхдээ Азийн Хөгжлийн Банк тухайн газар нутаг, нутаг дэвсгэрийн хууль эрх зүйн статусын талаар аливаа дүгнэлт хийх зорилго агуулдаггүй болно.

Салбар ба/эсвэл Дэд салбарын ангилал	–
Сэдэвчилсэн ангилал	–
Бодлого, үйл ажиллагаанд жендерийг тусгах талаарх ангилал	–

## ■ Санхүүжилт

Туслалцааны төрөл ба хэлбэр	Батламжийн дугаар	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан үнийн дүн (мянган ам.доллар)
Зээл	–	Ердийн хөрөнгийн эх үүсвэр	105,000
<b>НИЙТ</b>			<b>105,000 ам.доллар</b>

## ■ Хамгааллын арга хэмжээний ангилал

Хамгааллын арга хэмжээний ангиллын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.adb.org/site/safeguards/safeguard-categories> цахим хуудаснаас үзнэ үү.

---

Хүрээлэн буй орчин	B
Албадан нүүлгэн шилжүүлэлт	B
Нутгийн уугуул иргэд	C

---

## ■ Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй

Байгаль орчин

-

Албадан нүүлгэн шилжүүлэлт

-

Нутгийн уугуул иргэд

-

## ■ Оролцогч талуудтай харилцах, тэдний оролцоо ба хэлэлцүүлэг

Төслийн бэлтгэл ажлын явцад

-

Төслийн хэрэгжилтийн явцад

-

## ■ Тодорхойлолт

Санал болгосон төслийн хүрээнд Улаанбаатар хот болон түүний орчмын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг шинэчилэх замаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлж, дамжуулах, түгээх үед гарах алдагдлыг бууруулж, Улаанбаатар хотын цахилгаан станцуудаас гарч буй хүлэмжийн хийн болон бусад агаар бохируулагчийн ялгарлыг бууруулна. Уг төслийн хүрээнд мөн Тав дугаар цахилгаан станцын (ДЦС-5) төслийн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр боловсруулж буй Төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн загварыг санхүүгийн хувьд дүгнэн дуусгахад дэмжлэг үзүүлнэ. Төслийн бүрэлдэхүүн хэсэгт: (i) цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг сайжруулах; (ii) Диспетчерийн үндэсний төв, дамжуулах болон түгээх системийг цахимжуулах; болон (iii) чадавхи бэхжүүлэх зэрэг орно.

## ■ Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитай уялдаж буй байдал

---

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт түшиглэн хурдацтай өссөн (2013 онд 11.5%). Улаанбаатар хотод хотжилт хурдацтай явагдаж, аж ахуй, арилжааны үйл ажиллагаа нэмэгдэж байгаатай холбогдон цахилгаан, дулааны хэрэгцээ мөн өсөн нэмэгдсээр байна. Тийм хэдий ч дулаан, цахилгааны станц шинээр баригдаагүй учир энэ хэрэгцээг хангах боломжгүй байна. Улмаар Улаанбаатар хот болон бусад томоохон хотууд, уул уурхайн олборлолт явагдаж буй газруудыг хамардаг төвийн эрчим хүчний сүлжээний цахилгааны хэрэглээ 2012 онд 3,542 гигаВатт/цаг (ГВтц)-аар буюу 2003 онтой харьцуулбал 34 хувиар нэмэгдсэн байна. Төвийн эрчим хүчний сүлжээн дэх цахилгааны хэрэглээ 2015 онд 4,422 ГВтц-аар нэмэгдэж, 2025 он гэхэд 8,189 ГВт буюу 2012 оны түвшнөөс хоёр дахин өснө хэмээн тооцоолж байна. Дулаан, цахилгаан хангамжийн нөөц шавхагдах дөхсөн. Хангамжийн болзошгүй хомсдол үүсэхээс сэргийлэхийн тулд Улаанбаатар хотод ТХХТ-ээр шинэ ДЦС-5-ыг барин, ДЦС-4-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр Засгийн газар төлөвлөж байна. Шинэ ДЦС-5-ын барих болон ДЦС-4-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, Улаанбаатар хотын одоогийн хэрэглэгчдийг болон шинээр холбогдох иргэд, аж ахуйн нэгжүүдийг цахилгаан, дулаанаар найдвартай хангахын тулд Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани (ТБЦТС ТӨХК) ба Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (УБЦДС ТӨХК)-ний сүлжээг, мөн Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн харъяа дүүргүүдийн дулааны сүлжээ зэрэг холбогдох дэд бүтцийг сайжруулан өргөтгөх шаардлагатай юм. Ингэснээр ДЦС-уудад хийж байгаа хөрөнгө оруулалт бүрэн ашиглагдах боломж бүрдэнэ. Хөрөнгө оруулалт, засвар арчилгаа хангалтгүй хийгдсэнээс шалтгаалан одоо байгаа цахилгаан эрчим хүч дамжуулах болон түгээх дэд бүтцийн үйл ажиллагаа үр ашиггүй, надваргүй болсон бөгөөд тэдгээрийг сэргээн засварлах, сайжруулах шаардлага нэн тулгамдаж байна. 2012 онд цахилгаан түгээх шугамын алдагдал 19.6 хувь байсан нь олон улсын стандарт болох 5 хувиас хавьгүй илүү юм. Мөн 2012 оны байдлаар цахилгаан тасарсан хугацаа нэг хэрэглэгчийн хувьд 2,084.5 минут байсан ба доод тал нь 13 удаа тасарсан нь орчин үеийн цахилгаан түгээх аль ч сүлжээнд байж болохгүй өндөр үзүүлэлт байна. Дамжуулах ба түгээх сүлжээг сайжруулснаар эрчим хүчний алдагдал буурч, улмаар нүүрсний нэмэлт хэрэгцээнээс зайлсхийн, мөн хүлэмжийн хийн ялгарал болон бусад бохирдуулагчийн нөлөөллөөс сэргийлж, Монгол Улсын нийт хүн амын 40 хувь буюу 1.2 сая иргэдэд хүргэх цахилгаан эрчим хүчний үйлчилгээ илүү найдвартай, чанартай болох юм. Эдгээр хөрөнгө оруулалтаас гадна цахилгаан станцын үйл ажиллагаа эрхлэх лиценз (тусгай зөвшөөрөл) олгох, лицензийн тариф хянан батлах, эцсийн хэрэглэгчид ногдуулах тарифын саналыг Засгийн газарт хүргүүлэх зэрэг ажлыг хариуцдаг Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ)-ны чадавхийг бэхжүүлэх шаардлага нэн тулгамдаж байна. Монголд цахилгаан станц шинээр баригдаагүй удсан учир шинэ хөрөнгө оруулалтын ашгийг гаргах, салбарт эрчим хүчний үр ашигтай практик, туршлагыг нэвтрүүлэх боломжийг бий болгох дулаан, цахилгааны үнэ тариф тогтоох бодит туршлага ЭХЗХ-нд байхгүй байна. Ийм чадавх үгүйлэгдэж байгаа нь шинэ цахилгаан станцад хийгдэх хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж болзошгүй юм. Хоёр ДЦС-д их хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа тул энэ хэрэгцээ нэн тэргүүнд тавигдаж байна.

---

## ■ Хөгжлийн үр дүн

---

Монгол Улсын эрчим хүчний үйлчилгээ сайжирна.

---

## ■ Төслийн үр дүн

### Үр дүнгийн тодорхойлолт

### Үр дүнд хүрэх ажлын явц

Улаанбаатар хотын цахилгаан дамжуулах болон – түгээх системийн үр ашиг нэмэгдэнэ

## ■ Үр дүн ба хэрэгжүүлэх явц

### Төслийн үр дүнгийн тодорхойлолт

### Хэрэгжүүлэх явц, байдал (Үр дүн, үйл ажиллагаа ба асуудал)

Цахилгаан дамжуулах болон түгээх системийг – сэргээн засварлаж, өргөтгөх. ЭХЗХ-ны институцийн чадавхийг хөгжүүлэх.

### Хөгжлийн зорилтуудын байдал

### Биет өөрчлөлт

–

–

## ■ Бизнесийн боломж

**Анх жагсаалд оруулсан огноо** 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр

### Consulting Services

Бүхий л зөвлөх үйлчилгээг АХБ ба түүний Зээлдэгчийн Зөвлөх үйлчилгээг ашиглах журмын дагуу сонгон шалгаруулна (2013 он, тухай бүрт нь шинэчлэн найруулдаг).

### Худалдан авах ажиллагаа

Худалдах авах бүхий л ажиллагааг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын (2010 он, тухай бүрт нь шинэчлэн найруулдаг) дагуу гүйцэтгэн явуулна.

### Худалдан авах ажиллагаа болон зөвлөх үйлчилгээний мэдэгдэл

<http://www.adb.org/projects/46343-001/business-opportunities>

## ■ Цаглабар

### Концепцийг батлах

2014 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

### Урьдчилсан судалгаа

2015 оны 8 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүд

### Удирдлагаар хэлэлцүүлэх уулзалт

2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр

### Батлагдсан

–

### Сүүлд хийгдсэн хянан магадлах аичлал

–

## ■ Төлөвлөсөн график

Батламжийн дугаар	Батлагдсан	Гарын үсэг зурсан	Хүчин төгөлдөр болсон	Хаагдах		
				Анхдагч	Шинэчилсэн	Бодит
–	–	–	–	–	–	–

## ■ Ашиглалт

Огноо	Батламжийн дугаар	АХБ (Мянган ам.доллар)	Бусад (Мянган ам.доллар)	Цэвэр эзлэх хувь
<b>Эрх олгосон гэрээ, өссөн дүнгээр</b>				
–	–	–	–	–
<b>Зарцуулалт, өссөн дүнгээр</b>				
–	–	–	–	–

## ■ Гэрээний үүргийн статус

Гэрээний үүргүүд доорхи ангилалд хуваагдана. Үүнд: аудитоор хянагдсан тайлан мэдээлэл, хамгааллын арга хэмжээ, нийгэм, салбар, санхүү, эдийн засаг ба бусад. Гэрээний үүргийн биелэлтийг ангилал бүрээр доорхи шалгуур үзүүлэлтээр үнэлнэ: (i) Бүрэн хангалттай – ангилал дахь гэрээний бүх үүргийн биелэлтийг хангасан буюу нэг үүргийг биелүүлээгүй тохиолдолд, (ii) Зарим талаар хангалттай – ангилал дахь гэрээний 2 үүргийн биелэлтийг хангаагүй тохиолдолд, (iii) Хангалтгүй – ангилал дахь 3 ба түүнээс дээш гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд. 2011 оны Олон нийттэй харилцах бодлогоор гэрээний үүргийн биелэлтээр зэрэглэх шаардлагыг зөвхөн 2012 оны 4 дүгээр сарын 2 ба түүнээс хойш гэрээ байгуулах хэлцэл хийх урилга нь хүргэгдсэн төслүүдийн Санхүүгийн тайлан тооцоонд л ашиглах тухай заагдсан.

Батламжийн дугаар	Ангилал						Төслийн санхүүгийн тайлан
	Салбар	Нийгэм	Санхүү	Эдийн засаг	Бусад	Хамгааллын арга хэмжээ	
–	–	–	–	–	–	–	–

## ■ Холбоо барих ба мэдээллийг шинэчлэхэд

**АХБ-ны хариуцсан Ажилтан** Тэрүхиса Ои (teruhisaoi@adb.org)

**АХБ-ны хариуцсан Газар** Зүүн Азийн бүс нутгийн газар

**АХБ-ны хариуцсан хэлтэс** Зүүн Азийн бүс нутгийн газрын Эрчим хүчний хэлтэс

**Хэрэгжүүлэгч байгууллага** –

## ■ Холбоос

---

**Төслийн вэбсайт** <http://www.adb.org/projects/46343-001/main>

---

**Төслийн баримт  
бичгүүдийн жагсаалт** <http://www.adb.org/projects/46343-001/documents>

---